



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/158

Зуунмод

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт  
ажиллах зарим арга хэмжээний тухай

Зуунмод суманд Коронавируст /Ковид-19/ цар тахал бүртгэгдэж өнөөдрийн байдлаар батлагдсан тохиолдол 16-д хүрээд байна. Коронавируст халдварын тархалтын цар хүрээг тогтоох, голомтыг илрүүлэх зорилгоор “Нэг өрх-Нэг шинжилгээ” арга хэмжээг 03 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгуулж Зуунмод сумын 6 багийн 4912 өрхөөс 4489 өрхийн нийгмийн харилцаанд идэвхтэй оролцдог 1 гишүүнийг шинжилгээнд хамруулан халдвар сүүлийн 3 хоног дахин илрээгүй байгааг тэмдэглээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, 29.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3, 4 дүгээр зүйлийн 4.3, Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод суманд хөл хорионы дэглэмийг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 06:00 цагаас эхлэн Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын III буюу “Улбар шар түвшин”-д үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын III буюу “Улбар шар түвшин”-д Зуунмод суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн өмчит аж ахуй нэгж байгууллагууд хөл хорионы үеийн бэлтгэл бэлэн байдал, халдвар хамгааллын дэглэмийг бүрэн хангаж байгууллагын хэвийн үйл ажиллагааны хэвийн байдлыг алдагдуулахгүйгээр ажилтан, албан хаагчдын 30 хүртэл хувиар, бусад албан хаагчдыг албан үүргээ зайнаас гүйцэтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэн ажиллахыг хэлтэс, агентлаг, байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Онцгой байдлын газар Н.Төмөрбаатар, Цагдаагийн газрын дарга Б.Ганзориг, Зуунмод сумын Засаг дарга Ч.Сарангэрэл нарт ДААЛГАХ нь:

3.1. Хөл хорионы дэглэмийн үед мэргэжлийн байгууллагаас зөвшөөрөгдсөн хүнсний худалдаа, хүргэлтийн үйлчилгээ, эмийн сан, банк, шатахуун түгээх станц, харилцаа холбооны байгууллага, түлээ нүүрсний зах, мал эмнэлгийн үйлчилгээ, хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг тусгай нөхцөл, шаардлага зөвлөмжийн дагуу ариутгал халдваргүйтгэлийг бүрэн хийлгэж ажиллуулах;

3.2. Зуунмод суманд орох иргэдийг байнгын оршин суух хаягийг тодорхойлон Улаанбаатар хотоос ирэх бол 72 цагийн доторх PCR-шинжилгээний хариуг үндэслэн

замын шалган нэвтрүүлэх хяналтын цэг дээр түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж гэрийн ажиглалтад 7 хоног байлгаж халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэх, аймгийн бусад сумдаас байнгын хаяган дээр ирж буй иргэдийг түргэвчилсэн шинжилгээ авч нэвтрүүлэх;

3.3 Зуунмод суманд аймгийн бусад сумдаас хүндэтгэн үзэх шалтгаантай ирсэн иргэд голомттой бүс нутгаас 72 цагийн доторх PCR шинжилгээний хариутай гарч сумандаа очоод 7 хоног гэрийн ажиглалтад байна.

3.4 Зуунмод сумаас гарах иргэдийг зайлшгүй шалтгааныг тодорхойлох хүсэлт болон тухайн байнгын хаягт зорчихыг үндэслэн PCR-ын шинжилгээнд хамруулан гаргаж 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цаг хүртэл буцаж ирэхгүйгээр хязгаарлах;

3.5 Аймгийн хэмжээнд хүнсний татан авалт, шатахуун тээвэрлэлт, өвс тэжээл, эм эмнэлгийн хэрэгсэл, буяны ажил зэргийн зорчих хөдөлгөөнийг халдварын голомттой бүсээс 72 цагийн доторх (PCR) шинжилгээний хариутай иргэдийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж тухайн өдөртөө гарахыг иргэн, аж ахуйн нэгжид зөвлөх.

4. Халдвар илэрсэн иргэдийн нэг болон хоёрдугаар хавьтлыг тогтоож тусгаарлах арга хэмжээ авах, ажиглан тусгаарлах байруудын үйл ажиллагаа, гэрийн ажиглалтад байгаа иргэдэд тогтмол хяналт тавьж, халдвар хамгааллын дэглэмийг сахиулахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), Цагдаагийн газар (Б.Ганзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Улаанбаатар хот болон Зуунмод сумаас зорчиж буй иргэдийг оршин суух хаягийг тодорхойлж 72 цагийн доторх PCR шинжилгээний хариуг үндэслэн нэвтрүүлж гэрийн ажиглалтад 7 хоног байлгаж халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэх, шалган нэвтрүүлэх цэгүүдэд ажиллах эргүүл жижүүрийг тогтмолжуулан хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/157 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой комиссын орлогч, дарга бөгөөд Онцгой байдлын газрын дарга (Н.Төмөрбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР